

СУМЫН ЗАСАГ ДАРГА



БАТЛАВ

М.ЖАМЪЯНШАРАВ

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТӨВД ШАТАХУУН, ШАТАХ ТОСЛОХ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ  
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮНИЙН САНАЛ  
АВАХ БАРИМТ БИЧИГ**

БАТ-ӨЛЗИЙ СУМ  
2019 ОН

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

2019.03.14

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТӨВД ШАТАХУУН, ШАТАХ ТОСЛОХ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ  
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮНИЙН САНАЛ АВАХ  
БАРИМТ БИЧИГ**

**ТӨСЛИЙН НЭР:** *Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын ЭМТөвд  
шатахуун, шатах тослох материал нийлүүлэх*

**ТӨСЛИЙН ДУГААР:** ӨВАБӨСЗДТГ/201901017

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо:2019.01.19

Тендер шалгарулалтын нэр: **Бат-Өлзий сумын Эрүүл мэндийн төвд шатахуун, шатах тослох материал нийлүүлэх тендер**

Тендер шалгаруулалтын дугаар: **ӨВАБЭСЗДТГ/201901017**

**Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын ЗДТГ нь** эрх бүхий тендерт оролцогчдоос **Бат-Өлзий сумын Эрүүл мэндийн төвд шатахуун, шатах тослох материал** нийлүүлэх тухай **битүүмжилсэн** үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер шалгаруулалтын Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалтын журам”-ын дагуу зохион байгуулагдаж байна.

Тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авах боломжтой бөгөөд тендерт оролцохын тулд эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 /тавин мянган/ төгрөг цахим тендерийн хураамж төлнө.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэх 45 хоног хүчинтэй байна.

**Тендерт оролцогч нь:** Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.Үүнд:

- **Борлуулалтын хэмжээ:** 2018 оны борлуулалтын орлого төсөвт өртгийн 20 хувиас багагүй байх
- **Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ нь төсөвт өртгийн 20 хувиас багагүй
- **Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** 2018 он
- **Сүүлийн нэг жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** 2018 онд төсөвт өртгийн 20 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг гүйцэтгэсэн байна
- **Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:** Тийм

Тендерийг **2019 оны 04 -р сарын 04 -ны өдрийн 15 цаг 00 минут** -аас өмнө ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2019 оны 04 -р сарын 04 -ны өдрийн 15 цаг 30 минут** -т нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцохгүй**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Өвөрхангай Бат-Өлзий сумын ЗДТГ**  
**Санхүү албаны өрөө, Утас 95089588, 99293480**

Имэйл хаяг: [Bat-Ulzii@ov.gov.mn](mailto:Bat-Ulzii@ov.gov.mn)

Вэб сайт: [Bat-Ulzii.ov.gov.mn](http://Bat-Ulzii.ov.gov.mn)

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |  |
|---|--|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.  |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.   |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, татвар, нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт                                |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.   |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.  |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш “45” хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |
| <b>7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</b>            | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.<br>7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь <b>ТШӨХ-д</b> заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.<br>7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ |

байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ  
байгуулах эрх  
олгох тухай  
мэдэгдэл**

- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ
ТӨӨЗ 1.1	<p>- <b>2018 оны жилийн санхүүгийн тайлан</b> /<a href="http://www.mof.gov.e-balance.mn">www.mof.gov.e-balance.mn</a> цахим бүртгэлд шивэгдэн баталгаажсан байх/</p> <p>- <b>Сүүлийн /2017, 2018 аль нэг оны/ туршлагын мэдээлэл</b> /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, акт/</p> <p>- <b><u>Бусад нэмэлт шаардлага:</u></b></p> <ol style="list-style-type: none"> <li><b>1. ААНБайгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар</b> /нотариатаар баталгаажуулсан байх/</li> <li><b>2. Сүүлийн нэг жилд ашигтай ажилласан байх</b> /Борлуулалтын орлого тухайн тендерийн төсөвт өртгийн 20 хувиас багагүй/</li> <li><b>3. Харилцагч банкнуудын тодорхойлолт</b></li> <li><b>4. Харьяа татвар, нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт</b></li> </ol> <p>- <b>Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ</b> /шатахуун түгээх тусгай зөвшөөрөлтэй байх, нотариатаар баталгаажуулсан байх/</p> <p><b><u>Тендерт оролцогч ААНБ нь:</u></b></p> <ol style="list-style-type: none"> <li>Тендерт оролцогч боловсруулсан тендерийн иж бүрдэл, баримт бичгийг электрон хэлбэр /<b>Adobe PDF</b>/ - т хөрвүүлж цахим хэлбэрээр ирүүлнэ.</li> <li>Уг тендер нь цахим тендер шалгаруултын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч ААНБ нь төрийн худалдан авах систем /<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>/ -д ААНБ нт өөрийн цахим гарын үсэг /<b>PKI</b>/-аар нэвтрэн орж тендерийн бичиг баримтыг цахимаар авч, бэлтгэсэн тендерийн бичиг баримтаа цахим хэлбэрээр ирүүлнэ.</li> <li>Захиалагч шалгарсан тендерт оролцогч ААНБ-ын мэдээлэл болон санхүүгийн мэдээллийг олон нийтэд мэдээллэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан тоот ирүүлэх</li> </ol>
ТӨӨЗ 2.1	<p><b><u>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</u></b></p> <p>Байгууллагын хаяг: <b>Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум, 5-р баг, ЗДТГ, Санхүүгийн алба</b></p> <p>Огноо: <b>2019 оны 04 сарын 04-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>15 цаг 00 минут</b></p> <p><b>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим худалдан авах системийн /<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>/-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийг хүлээн авах боломжгүй.</b></p>
ТӨӨЗ 2.2	<p><b><u>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</u></b></p> <p>Байгууллагын хаяг: <b>Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум, 5-р баг, ЗДТГ, Санхүүгийн алба, Утас: 95089588, 99293480</b></p>

	<p>Огноо: <b>2019 оны 04 сарын 04 ны өдөр</b></p> <p>Цаг: <b>15 цаг 30 минут</b></p>
<b>ТӨӨЗ 6.2</b>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь багцгүй.</p> <p>Төсөвт өртөг: <b>23 113 000 /Хорин гурван сая нэг зуун арван гурван мянган төгрөг 00 мөнгө/</b></p>

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

- 1. Барааны тодорхойлолт:** *Чанарын шаардлага хангасан шатах, тос тослох материал /А80 бензин, А92 бензин, дизель түлш, тос, тосол, тормосны шингэн, тап зэргийг нийлүүлэх/*
- 2. Бараа хүргэх газар:** *Бат-Өлзий сумын ЭМТөө*

**Шатахуун нийлүүлэгч нь:**

- ✓ *Аж ахуйн нэгжтэй байх*
- ✓ *Шатахуун түгээх зөвшөөрлийн гэрчилгээ*
- ✓ *Карт уншигчтай байх*
- ✓ *НӨАТ-ын баримт хэвлэгч машинтай байх*
- ✓ *Ажиллах хүчтэй байх /Ажилчдын талаар мэдээлэл ирүүлэх/*

**БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
А80 бензин	Стандартын шаардлага хангасан	1600	л	ЭМТ	2019 оны 1 сараас	2019 оныг дуустал	
А 92 бензин	Стандартын шаардлага хангасан	9700	л	ЭМТ	2019 оны 1 сараас	2019 оныг дуустал	
Дизель түлш	Стандартын шаардлага хангасан	800	л	ЭМТ	2019 оны 1 сараас	2019 оныг дуустал	
Тос, тосол	Стандартын шаардлага хангасан	60	л	ЭМТ	2019 оны 1 сараас	2019 оныг дуустал	
Тормосны шингэн	Стандартын шаардлага хангасан	22	л	ЭМТ	2019 оны 1 сараас	2019 оныг дуустал	
Тап	Стандартын шаардлага хангасан	10	л	ЭМТ	2019 оны 1 сараас	2019 оныг дуустал	
Масло /мобель/	Стандартын шаардлага хангасан	20	л	ЭМТ	2019 оны 1 сараас	2019 оныг дуустал	



Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
A-92							
A-80							
Дизель дүли							
Тос тосол							
Тормосны шингэн							
Тап							
<b>Тендерийн нийт үнэ</b>							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Шалгах болон турших</b>                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b> | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| <b>3. Оюуны өмчийн эрх</b>                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| <b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| <b>5. Баталгаат засварын хугацаа</b>                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[моо]</b> жил байна.   |
| <b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| <b>7. Төлбөр</b>  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан моо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| <b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| <b>9. Алданги оногдуулах</b>                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| <b>10. Үүргээ биелүүлээг үй-гээс гэрээг цуцлах</b>        | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| <b>11. Маргааныг шийдвэрлэх</b>                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
  - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
  - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
  - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
  - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
- 4. Төлбөр (ГЕН – 7)**
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[тоо]**<sup>1</sup> хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>2</sup>**
- 9.1. Алданги оногдуулах хувь: **[тоо]**
- Алдангийн нийт дүн: **[тоо]**

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

<sup>2</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

**ЗАХИАЛАГЧ**

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>4</sup>;  
Үнийн санал;

<sup>3</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>4</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*